


Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2017 оны 07 дүгээр сарын 06-ны
өдрийн 106 дугаар тогтоолын хавсралт 1




ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хамтын удирдлагын менежментийг нэвтрүүлэх замаар өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.2. Энэ журмын 1.1-д заасан өмчийн төлөөллийг орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн дэргэд Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "Төлөөлөн удирдах зөвлөл" гэх/ байгуулан ажиллуулах хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 1.3. Журмыг Дүүргийн өмчийн хуулийн этгээд болох орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дагаж мөрдөнө.


Хоёр. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх

- 2.1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах гишүүнийг Хан-Уул дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр томилж, өөрчилнө.
- 2.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. 1 гишүүнийг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас, 4 гишүүнийг Засаг дарга нэр дэвшүүлнэ.
- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх нь дараагийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд томилогдсоноор дуусгавар болно.
- 2.4. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд томилогдсон гишүүд нь өөрсдийн дундаас олонхийн санал авсан гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгон тогтоолоор баталгаажуулж, мөн чөлөөлж, дахин сонгоно.
- 2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд гишүүд нь нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдохгүй.
- 2.6. Төлөөлөн удирдах зөвлөлийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих чиг үүргийг Хан-Уул дүүргийн Засаг дарга хэрэгжүүлнэ.



Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

- 3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлыг тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсноор зарлан хуралдуулна.
- 3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа заавал хуралдуулах бөгөөд хуралд нийт гишүүдийнх нь олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гишүүд биеэр оролцох үүрэгтэй.
- 3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний саналын эрхийг нөгөө гишүүнд шилжүүлэх, саналын эрхийг өөр этгээдэд итгэмжлэлээр дамжуулахыг хориглоно.
- 3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хурлаар хэлэлцэж буй аливаа асуудалд хууль тогтоомжийн хүрээнд, үнэн зөв мэдээлэлд үндэслэн орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах үүрэгтэй.
- 3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд шалтгаанаа Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад урьдчилан мэдэгдэж, хуралд бичгээр санал өгч болох бөгөөд энэ тохиолдолд хуралд оролцсонд тооцно. Нэг удаагийн хуралд 2-оос дээш гишүүний саналыг бичгээр авахгүй бөгөөд нэг гишүүн дараалан 2-оос дээш хуралд бичгээр санал ирүүлэхийг хориглоно.
- 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ:
- 3.7.1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн дүрмийн болон бүтэц, орон тооны төсөл;
- 3.7.2. Захирлын Хан-Уул дүүргийн Засаг даргатай байгуулсан контрактын хэрэгжилт /хагас, бүтэн жилээр/;
- 3.7.3. Захирлын ажлын тайлан, бизнес төлөвлөгөөний төсөл;
- 3.7.4. Захирлын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт;
- 3.7.5. Хуулийн этгээдийн хөдөлмөрийн дотоод журам болон эрх зүйн бусад бичиг баримтуудын төсөл;
- 3.7.6. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт;
- 3.7.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв;
- 3.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь гүйцэтгэх удирдлага болон нарийн бичгийн даргаар дамжуулан өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, тайлан, мэдээлэл зэргийг аман болон бичгийн хэлбэрээр авах эрхтэй.
- 3.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэгдээгүй асуудлыг Захирал, гүйцэтгэх удирдлагын баг шийдвэрлэхгүй.
- 3.10. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга зарлан хуралдуулна. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал хуралдуулах тухай саналыг гишүүд болон тухайн хуулийн этгээдийн дарга тус тус гарган нарийн бичгийн даргаар дамжуулан зөвлөлийн даргад гаргах бөгөөд энэ



саналыг гишүүдийн олонхи дэмжсэнээр санал хүчин төгөлдөрт тооцогдож хурлыг заавал хуралдуулна.

3.11. Шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга өөрийн санаачлагаар хурлыг хуралдуулна.

3.12. Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн хуулийн этгээдийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, эзэмшил, ашиглалт, захиран зарцуулалт, ашигт ажиллагааны түвшинг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүн, санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор Хан-Уул дүүргийн Засаг даргад өргөн мэдүүлнэ.

3.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлыг дүгнэсний үндсэн дээр компанийн захирлын урамшууллын дүнгийн 25 хувь хүртэлх хэмжээний төгрөгийн урамшууллыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрт олгож болно.

Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг

4.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулж, удирдана.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтлүүлж /бичлэг/, тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулна.

4.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Захирал болон хуулийн этгээдийн бусад удирдах ажилтнуудтай харилцаа холбоотой ажиллана.


4.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гишүүдийг санал бодлоо чөлөөтэй солилцох нөхцлөөр хангана.

4.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон гишүүн гүйцэтгэнэ.

4.6. Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэх асуудлын төслийг нарийн бичгийн даргаас хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хурлын товыг баталгаажуулна.

4.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хуралд оролцож буй гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг өөрийн саналаар шийдвэрлэх давуу эрхтэй.

4.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар санхүү, бизнесийн үйл ажиллагаанд шалгалт хийх асуудлыг хэлэлцэн олонхийн саналаар гаргасан шийдвэрийг Хан-Уул дүүргийн Засаг даргад танилцуулна. Шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ.



**Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн
даргын эрх, үүрэг**

5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг тухайн хуулийн этгээдийн санал болгосон нэр дэвшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилж, чөлөөлнө.

5.2. Нарийн бичгийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлын төслийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар батлуулан, гишүүдэд хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, холбогдох баримт бичгийг биечлэн болон баталгаат шуудангаар гишүүдэд хүргүүлнэ.

5.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын талаархи саналыг гишүүдээс хүлээн авч, тухайн саналтай холбоотой мэдээлэл, тооцоо, судалгаа зэрэг бичиг баримтыг бэлтгэнэ.

5.4. Мэдээллийг нийтэд хүртээмжтэй хүргэх арга хэмжээ авч, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана.

5.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад танилцуулна.

5.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлийг хөтөлж, тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд, хурлаас гарах шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, хурал дууссанаас хойш ажлын 3 /гурван/ хоногт багтаан баталгаажуулна. Баталгаажуулсан тэмдэглэл, шийдвэрийн хадгалалт, хамгаалалтыг хариуцаж ажиллана.

5.7. Төлөөлөн удирдах зөвлөлд компанийн сайн засаглалын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлнэ.


5.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, хэрэгжилт, биелэлтэнд тавих хяналтын талаархи тайланг улирал тутам Хан-Уул дүүргийн засаг даргад хүргүүлнэ.

5.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын цалин нь Төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд тусгагдана.

**Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үйл ажиллагаанд
хориглох зүйл болон хариуцлага**

6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно.

6.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлд Хан-Уул дүүргийн төлөөллийг хэрэгжүүлэх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь тухайн орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаатай ижил чиглэлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг байхыг хориглоно.



6.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлд нь ажиллаж буй орон нутгийн өмчийн хуулийн этгээдээс бэлэг, үйлчилгээ, зээл, тусламж авах, хөнгөлөлт эдлэхийг хориглоно.

6.1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нэгдмэл сонирхолтой этгээдийг санал болгох, захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.

6.2. Хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

6.3. Энэ журамд заасныг зөрчсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дараах хариуцлага хүлээлгэнэ.

6.3.1. Журмын 6.1.1-д заасныг зөрчсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг Хан-Уул дүүргийн засаг даргаас түүнийг томилсон этгээдэд хүргүүлнэ.

6.3.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд биеэр оролцоогүй, орон нутгийн өмчийн төлөөлөгчийн үүрэгтэй холбогдсон ажил үүргээ гүйцэтгээгүй нөхцөлд тухайн сард ногдох цалинг олгохгүй.

6.3.3. Журмын 6.1.2, 6.1.3-т заасныг зөрчсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг түүнийг томилсон этгээдийн шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлүүлж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хариуцлагаас зөрчилд тохирох хариуцлага хүлээлгэх саналыг Хан-Уул дүүргийн засаг даргаас түүнийг томилсон этгээдэд хүргүүлнэ.

